MERIT
A CESO AND WUSC PROGRAM

Макро түвшний хүчин зүйлсийг ойлгохын тулд том зургаар харах нь

Мишэл Филион, Төрийн удирдлагын зөвлөх

Агуулга

- Макро түвшний хариуцлага
- Улсын салбарын эдийн засаг
- Татвар ба орлогын үр нөлөө, нөлөөлөл
- Макро түвшин дэх зөрүүтэй байдал, нийгэмд чиглэсэн төсвийн зарлагын сонголт
- Нарийвчилсан шинжилгээ, шийдвэр гаргалт
- Нийгэмшүүлэх болон соёлын бодлого

mfilion@ign.quebec

Макро түвшний хариуцлага

- Охид эмэгтэйчүүд нийгэм, улс төр, соёл, эдийн засгийн хүрээнд эрхээ бүрэн эдлэхэд олон саад бэрхшээлтэй тулгардаг. Төр эдгээр саад бэрхшээлийг арилгаж, эмэгтэй, эрэгтэй хүмүүсийн хооронд тэгш байдлыг бодитойгоор тогтоох үүрэгтэй.
- Макро-эдийн засгийн бодлого нь жендэрийг авч үзэхгүйгээр эдийн засгийн ерөнхий үзүүлэлтүүдийг анхаарч зохицуулдаг. Энэ нь жендэрийн мэдрэмжгүй бодлого юм.

mfilion@ign.quebec

Макро эдийн засаг

Макро эдийн засгийн бодлогын зорилтуудыг ихэвчлэн нарийн тодорхойлсон байдаг бөгөөд нийт эдийн засгийн өсөлтийг хурдасгаж, санхүүгийн тогтвортой байдлыг хангахад чиглэгдсэн байдаг. Гэвч бодлогын өргөн хүрээний зорилт, нийгэмд үзүүлэх үр өгөөжөөс илүүтэйгээр эдийн засгийн өсөлт, мөнгө санхүүгийн зорилтот түвшинд хэт анхаардаг нь эдийн засгийн бүхий л бодлого эцсийн зорилгоосоо (бүх хүн эдийн засаг, нийгмийн хүрээнд эрхээ бүрэн эдлэх боломж олгох) хазайхад хүргэдэг.

mfilion@ign.quebec

Тогтолцооны гажуудал

- Өнөөдрийн макро-эдийн засгийн тогтолцоо нь эмэгтэйчүүд цалингүй асран халамжлах ажлыг (хоол хийх, гэр орноо цэвэрлэх, гэр бүлийнхээ хүүхэд, хөгшид, өвчтэй хүмүүсийг асрах) дангаараа үүрэх зэрэг гажуудлыг шийдвэрлэж чадахгүй байна.
- Хэдийгээр цалингүй асран халамжлах ажлыг хэмжиж, үнэлж, тусгадаггүй боловч энэ нь аливаа эдийн засгийн бүтээгдэхүүн, үйлчилгээний үйлдвэрлэлд төдийгүй охид эмэгтэйчүүд эрхээ зохих ёсоор эдлэхэд шууд нөлөөлж байна.

mfilion@ign.quebec

Улсын салбарын эдийн засаг

Төрийн бодлогыг эдийн засгийн үр ашиг, тэгш эрхийн талаас нь судлан шинжлэхийг хэлнэ. Улсын салбарын эдийн засаг нь халамжийн эдийн засгийн онолд тулгуурладаг бөгөөд үүнийг эцсийн дүнд нь нийгмийн халамжийг сайжруулах арга хэрэгсэл байдлаар ашигладаг.

mfilion@ign.quebec

Татвар, төсвийн орлого

Засгийн газрын орлого бүрдүүлэх арга зам нь эмэгтэй, эрэгтэй хүмүүст ялгаатай нөлөөлдөг. Жендэрийн тэгш байдлын үзэл баримтлалыг татварын ерөнхий бодлогод тусгах нь төрийн бодлогын чанарыг мэдэгдэхүйц сайжруулдаг.

mfilion@ign.quebec

Жишээ: Татвар

Тухайлбал, өсөн нэмэгдэх хувь хэмжээ бүхий хувь хүний орлогын албан татварын тогтолцоо нь гэрлэсэн хосууд хамтдаа татвар төлөх боломжийг олгодог улс орнуудад бага орлого олж буй хүнд ч гэсэн тогтоосон дүнгээс илүү гарсан орлогод өндөр хувь хэмжээтэй татвар ногдуулдаг. Энэ нь эмэгтэйчүүдийн орлого ихэвчлэн нөхрийнхөөсөө бага байдаг тул эмэгтэйчүүдэд эрэгтэйчүүдээс илүү нөлөөлөх нь олонтоо.

Макро түвшний зөрүү

Жендэрийн цалингийн зөрүү

Боловсролын түвшний зөрүү

Тэтгэврийн зөрүү

Улс төр дэх оролцооны зөрүү

Шийдвэр гаргах албан тушаал дахь зөрүү

Хөрөнгө мөнгө эзэмших байдал дахь зөрүү.

mfilion@ign.quebec

Төсвийн зарлагын сонголт

Хүүхэд халамжлах тогтолцоог дэмжихийн ач холбогдол

Хүүхдээ асрахад дэмжлэг үзүүлэхийн ач холбогдол

Шимтгэл төлөөгүй ч тэтгэвэр авах нь ахмад насны эмэгтэйн амьжиргаанд эерэгээр нөлөөлнө.

Нийтийн тээвэр эмэгтэйчүүдийн амьдралын чанарт чухал ач холбогдолтой.

Олон нийтэд тэгш байдлын талаарх мэдлэг түгээх тогтолцоо, номын сангийн ач холбогдол

mfilion@ign.quebec

Нарийвчилсан шинжилгээ

Одоог хүртэл бид төрийн байгууллагын зарцуулж буй зардлын нэн даруй гарах үр дагаврыг хэмжих талаар ярьсан. Бид байгууллага оршин байгаа үндэслэл, өөрийн үйл ажиллагааны эрэгтэй, эмэгтэй хүмүүс болон бусад бодит харилцан хамаарал бүхий хүн ам, нийгмийн үзүүлэлтэд нөлөөлж буй гол хүчин зүйлсийг анхаарч судалвал зохино.

mfilion@ign.quebec

Нийгэмшилд төрийн үзүүлэх нөлөө

- Төр олон нийтэд боловсрол олгох, соён гэгээрүүлэхэд чиглэсэн арга хэмжээгээрээ дамжуулан хүүхдүүдийг хэрхэн нийгэмшүүлэх талаар ямар мэдээллийг хүн ам, айл өрх, эцэг эхчүүдэд өгч байна вэ?
- Уг мэдээлэл нь тэгш бус байдлыг өөгшүүлж байгаа эсэх?

mfilion@ign.quebec

Соёлын бодлого

- Соёл, түүх, үлгэр домогт эмэгтэйчүүд хэрхэн, хэр зэрэг гардаг вэ? Бид тэдний хувь нэмрийг эн тэнцүү авч үздэг үү? Тэдний оруулж буй хувь нэмрийг зөвөөр үнэлж хүлээн авдаг уу?
- Бид ямар төрлийн соёл бий болгодог вэ?

mfilion@ign.quebec



Merci.